



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.02.07 № 01/279
танай _____-ны № _____-т

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГА Ц.БАТЗУЛ ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд мэдээллийн нэгдсэн шинэ системийг нэвтрүүлэх, 1995-2023 онуудын өгөгдөл мэдээллийг хөрвүүлэх ажил үе шаттай хийгдэж байгаатай холбогдуулан дараах мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

1. Ажил олгогчийн шимтгэл төлөлтийн 2024 оны 01 дүгээр сарын тайлан илгээх хугацааг 02 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл сунгасан тул ажил олгогчийн болон даатгуулагчийн шимтгэл төлөлтийн мэдээлэл 2023 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар гарна.

2. Ажил олгогч байгууллагын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үүссэн нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг төлсөн эсэх лавлагаа бусад холбогдох мэдээллийг харьяа Нийгмийн даатгалын газруудаас цаасаар гаргаж байна.

3. Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөлтийн болон бусад холбогдох мэдээллийг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд цахимаар солилцох боломжгүй байна.

Иймд танай байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд өмнө нь цахимаар солилцож байсан ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөлттэй холбоотой мэдээллийг 2023 оны 12 дугаар сар болон түүнээс өмнөх хугацаагаар авч, Нийгмийн даатгалын байгууллагуудаас цаасаар гаргасан лавлагаа, тодорхойлолтыг үйл ажиллагаандаа ашиглахыг хүсье.

Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг шинэ программ хангамжид хөрвүүлэх ажил бүрэн хийгдэж, шинэчилсэн системийн хэвийн ажиллагаа хангагдсанаар цахим мэдээлэл солилцох боломжтой болох бөгөөд системийн талаарх мэдээллийг тухайн хугацаанд нь хүргүүлэх болно.

Таны хамтын ажиллагаанд талархсан;

ДАРГА



Л.МӨНХЗУЛ